The verb **болох** is very versatile and appears in many contexts: (1) ‘to be’ in time expressions, as we have seen (page 78); (2) ‘to become’ as in **эрүүл болох** ‘to grow healthy’; (3) ‘to acquire’ with the comitative case **тэрэгтэй болсон** ‘got a cart’; (4) ‘to decide’ as in **явах болсон** ‘decided to go’; and (5) ‘to be enough’, ‘sufficient’ as in Dialogue 3 **Архи болно!** ‘That’s enough vodka!’

Other points

We saw earlier some participatory verbs (derivational suffix **-цгаа-**) where the action is carried out in a group. Here we have **Тогтооцгоов** ‘(They) drank up together’ derived from the participatory form **тогтооцгоох** ‘to drink up together’ of **тогтоох** ‘to drink up’ (and also ‘to establish’ and ‘to memorize’).

The verb **ях** and **ч** combine in the expression **Яахын ч аргагүй!** ‘There’s nothing to be done! Can’t be helped!’

Julie says **Аль аймгаар явахаа товлоогүй** ‘We haven’t decided yet which provinces we’ll be going round’ where **явахаа** is the present-future verbal noun **явах** plus the reflexive (accusative) ending **-аа**: ‘our going round’.

Exercise 7

Translate into Mongolian:

- 1 Oyuun certainly speaks Russian.
- 2 Is Sükh still working at the Ministry of External Relations?
- 3 I went to the central post office to send something to my elder brother.
- 4 Mr Brown plans to go to the country with his wife next week.
- 5 Bat jumped up and went off.

Exercise 8

Supply the causative forms of the following verbs and translate them into English:

- 1 явах 2 орох 3 бичих 4 үзэх 5 гэрлэх

Exercise 9

Translate into English:

- 1 Ерөөлөөр болог! Ерөөлөөр болтугай!
- 2 Яахын ч аргагүй.
- 3 Тэгэлгүй яах вэ.
- 4 Бололгүй яах вэ.
- 5 Байлгүй яах вэ.

Dialogue for comprehension 4 

- Бат: Та нар маргааш орой завтай юу?
- Девид: Завтай байлгүй яах вэ. Юу гэж?
- Бат: Нэг сайхан ресторанд оръё. Бидэнтэй хамт явна уу?
- Девид: За, тэгье. Хотын аль ресторан хамгийн сайн бэ?
- Бат: «Мандухай», «Улаанбаатар» зочид буудлын ресторан хоёр хамгийн сайн.
- Девид: «Мандухай» ресторан их сайн хоолтой.
- Бат: Хэрэв тийм бол «Мандухай» явъя.
- Девид: За, маргааш хэдэн цагт вэ?
- Бат: Долоон цаг арван таван минутад.
- Девид: Болно. Зочид буудлын ресторанд уулзъя?
- Бат: Тэгье.
- (дараа өдөр нь)
- Жюли: Та нар юу авах вэ?
- Дэлгэрмаа: Би улаан лоолийн шөлөнд их дуртай.
- Жюли: Улаан лоолийн шөл байна уу?
- Үйлчлэгч: Байхгүй, дуусчихсан. Харин будаа, ногоотой шөл байна.
- Жюли: Та нарыг будаатай шөл авбал би ногоотой шөл авна.
- Девид: Би ногоон хоолтон биш, ногоотой шөлөнд дургүй, хонины маханд дуртай.

Дэлгэрмаа: Хэрэв тийм бол хоёр будаатай шөл бас нэг ногоотой шөл авъя.

Үйлчлэгч: Тэгье.

Жюли: Би хоёрдугаар хоолонд шарсан гахайн мах авмаар байна.

Дэлгэрмаа: Бат бид хоёр тахианы шарсан мах авъя.

Жюли: Ямар ямар ногоо байна?

Үйлчлэгч: Чанасан төмс, сонгино, шар лууван бий.

Девид: Тэрнээсээ бидэнд авчираарай!

Үйлчлэгч: Та нар уух юм юу авах вэ?

Жюли: Би «Русское шампанское» уумаар байна. Шилээрээ их хямдхан. Таныг надтай хамт уувал би их жаргалтай байна. Уулзсаны баяр хийе.

рашаан ус	mineral water	хар цай	black tea
шүүс(н)	juice	пив(н)	beer
ногоон хоолтон	vegetarian	дарс(н)	wine
нимбэгний ундаа	lemonade	оргилуун дарс	sparkling wine
шампанск	champagne	чацаргана	sea buckthorn

Note: «Русское шампанское» or 'Russian champagne', formerly «Советское шампанское» 'Soviet champagne' is a sparkling wine still bottled with this label in Odessa, Riga and elsewhere. The yellow berries of sea buckthorn are used to make two drinks, a thick sweet juice and a white fruit wine.

Улаанбаатарын хэдэн ресторан

ЖАЛСРАЙ РЕСТОРАН

Сөүлийн гудамж (Оросын элчиний урд залуу техникчдын ордонд) Утас: 314304
Өдөр бүр 12.00-22.00
Гал тогоо: Хот дог, кекс, саалад, пицца, тахиа

ЖАРГАЛАН РЕСТОРАН

Ард Аюушийн гудамж (Монгол эмэгтэйн сүү самарч байгаа хөшөөний хажууд)
Утас: 368035
Өдөр бүр 12.00-01.00
Гал тогоо: Хятад болон европ хоол

НЬЮ КАПИТАЛ РЕСТОРАН

Энх тайваны өргөн чөлөө Нью Капитал зочид буудал
Утас: 358235
Өдөр бүр 09.00-01.00
Гал тогоо: Монголын болон европийн хоол

ПИЦЦА ФАСТ ФООД

Энх тайваны өргөн чөлөө (Оросын элчин сайдын яамаас урагш)
Утас: 322859
Өдөр бүр 10.00-01.00
Гал тогоо: Төрөл бүрийн пиццагаар гээрээр үйлчилнэ

МАРКО ПОЛО РЕСТОРАН

Дөрвөн уул захын урд 4
 давхар зочид буудалд
 Утас: 310783
 Өдөр бүр 12.00-21.00
 Европийн 20 төрлийн хоол

МОСКВА РЕСТОРАН

3-р хороолол шанага барьсан
 монгол эмэгтэйн хөшөөн урд
 Утас: 360361
 Өдөр бүр 10.00-22.00
 Гал тогоо: Орос болон
 европ хоол

СӨҮЛ РЕСТОРАН

Хүүхдийн найрамдал парк,
 хуучин Туяа ресторан
 Утас: 326554
 Өдөр бүр 12.00-22.00
 Солонгос тогоочидийн
 бэлтгэсэн олон орны төрөл
 бүрийн хоол

ПРАГ РЕСТОРАН

Амарсанаагийн гудамж
 (Гандангийн баруун талд)
 Утас: 366218
 Өдөр бүр 10.00-20.00
 Чех болон олон улсын хоол

СОЛОНГО РЕСТОРАН

Сөүлийн гудамж, Хүүхэд
 залуучуудын театрын урд
 Утас: 329675
 Мягмараас бусад өдөр
 12.00-22.00
 Европ болон монгол хоол

СЭЛЭНГЭ РЕСТОРАН

Сансарын Жинпан дэлгүүрийн
 зүүн тийш 2 давхар байшин
 Утас: 56935
 Өдөр бүр 08.00-04.00
 Орос болон европ хоол

гал тогоо(н)	cuisine	самрах	to stir, ladle
гэрээр үйлчлэх	home delivery	солонгос	Korea(n)
жаргалан(г)	happiness	төрөл	kind
залуу	young	шанага(н)	ladle

Note: The **эмэгтэйн сүү самарч байгаа** 'stirring milk' **хөшөө** and **шанага барьсан** 'holding a ladle' **эмэгтэйн хөшөө** are the same. **Сансар** 'Cosmos' is a district.

5 Давс хийвэл уустал, ажил хийвэл дуустал

Never do things by halves

In this lesson you will learn:

- How indirect speech is structured
- Ordinal numbers and days of the week
- Another form of the imperative
- The terminal converb (until)
- The continuous converb (keeps on)

Dialogue 1

Жуулчид их очдог гурван газар
Three places much visited by tourists

Bat tells David and Julie about three places tourists visit in the Mongolian countryside.

Бат: Би жуулчдад зориулсан нэгэн сонирхолтой лавлах ном уншиж байна.

Девид: Түүнийг над үзүүлээч!

Бат: Жаахан жүлээж бай! Энэ номд «Жуулчид их очдог говь нутгийн нэгэн сайхан газар нь Гурван Сайхан уулын Ёлын ам гэдэг дархан цаазат газар билээ» гэж байна. Энэ газар Өмнөговь аймагт байдаг юм.

Девид: Алив надад өг дөө наад номоо!

Бат: Та сонсооч. «Жуулчдын анхаарлыг их татдаг хоёр дахь газар бол Хангайн уулархаг орон юм. Дэлхий дахинд нэрд гарсан Хар Хорумыг хуучин балгасын хамт үзэж сонирхсон хүн маш олон байна».

- Жюли: Ойлголоо. Жуулчид их цугладаг гуравдахь газар хаа байна вэ?
- Бат: Жуулчид их цугладаг гурав дахь нутаг бол «Хэнтий уулархаг бүсэд хамаарах Тэрэлж билээ» гэж бичсэн байна. Тэрэлж эндээс хол биш. Улаанбаатараас зүүн хойд зүгт оршдог юм.
- Девид: Тэрэлж рашаантай юу гэж асуувал болохсон болов уу?
- Бат: Энэ лавлахад «Тэрэлжийн нэг онцлог бол энэ хавийн геологийн тогтоц тун өвөрмөц байгаад оршино» гэж бичжээ. Бас зарим хаданд агуй ч байдаг гэж бичсэн байна. Гэвч Тэрэлжийн рашааны тухай юу ч бичээгүй байна.
- Жюли: Бид Хар Хорум руу яаж явах вэ?
- Бат: Та УАЗ машин юм уу онгоцоор Хархорин хот руу явж болно. Бас өдөр бүр автобус явж байгаа. Энэ автобус Тээврийн товчоо гэдэг газраас явдаг юм. Миний бодлоор Хар Хорум руу очилгүй бол болохгүй.
- БАТ: *I'm reading an interesting guidebook for tourists.*
- DAVID: *Show it to me!*
- БАТ: *Wait a bit! This book says, 'One of the places in the Gobi much visited by tourists is the Yolyn Am (Vulture Gorge) reserve in the Gurvan Saikhan (Three Beauties) mountains.' This place is in South Gobi province.*
- DAVID: *Come on, give me this book!*
- БАТ: *Listen: 'The second place to which tourists' attention is greatly attracted is the Khangai mountain area. Very many people have been interested in seeing world-famous Karakorum with the old city ruins.'*
- JULIE: *I understand. Where is the third place that tourists gather a lot?*
- БАТ: *The third place where tourists gather a lot is 'Terelj, which is part of the Khentii mountain zone'. Terelj is not far from here, it is north-east of Ulan Bator.*
- DAVID: *I wonder if perhaps I could ask you whether there is a spring at Terelj.*
- БАТ: *This guidebook says that 'one of the features of Terelj is the peculiar geological structure situated nearby'. It says also that in some cliffs there are even caves. But it doesn't say anything about a Terelj mineral spring.*
- JULIE: *How can we get to Karakorum?*

ВАТ: *You can go to Kharkhorin town by UAZ [Russian-made four-wheel drive cross-country vehicle] or by plane. There is also a daily bus. The bus goes from the Transport Office [Ulan Bator]. In my opinion one really must visit Karakorum.*

Note: The Gobi zone, on the border between Mongolia and China, comprises South Gobi (**Өмнөговь**), Middle Gobi (**Дундговь**) and East Gobi (**Дорноговь**) provinces (see map). Gobi is mostly not desert but defined as 'steppe plain where vegetation is sparse, trees and flowing water are very rare, the topsoil is sandy or gravelly, and no marmots (**гарвага**) live' (quotation from Tsevel, Y. (1966) *Concise Explanatory Dictionary of the Mongolian Language*, Ulan Bator: State Publishing Committee). Gobi terrain also extends across Gobi-Altai (**Говь-Алтай**) province, named after the mountain range. The Khangai mountains give their name to the central Mongolian provinces of Arkhangai (**Архангай**) and Övörkhangai (**Өвөрхангай**), meaning literally the 'back' (**ар**) and 'breast' (**өвөр**) of the Khangai, i.e. the northern and southern slopes. Karakorum (marked on the map) and nearby Kharkhorin town are in Övörkhangai. The Khentii mountains are to be found in Central (**Төв**) and Khentii (**Хэнтий**) provinces, while Terelj is an hour's drive from the capital.

ШИНЭ ҮГ **Vocabulary**

автобус(н)	bus	нутаг	territory
агуй	cave	нэрд гарсан	famous
ам(н)	mouth; gorge	онцлог	feature
анхаарал	attention	өвөрмөц	peculiar
балгас(н)	ruin(ed town)	сонирхох	to take interest
болов уу	perhaps	сонсох	to listen
бүс	zone, belt	татах	pull, attract
геологийн	geological	товчоо(н)	office, bureau
дархан цаазат	nature	тогтоц	structure
газар	reserve	тун	very
дэлхий(дахин)	world(-wide)	тээвэр	transport
зарим	certain	уулархаг	mountainous
ёл	vulture	хавь	vicinity
маш	very	хад(ан)	rock, cliff
наад	this here	хамаарах	to belong to
онгоц(н)	vessel, ship	цааш	further
нисэх онгоц(н)	aeroplane	цуглах	to gather

Note: The towns of Darkhan, Erdenet and Choir (Дархан, Эрдэнэт, Чойр) shown on the map in Selenge, Bulgan and East Gobi provinces (Сэлэнгэ, Булган, Дорноговь), are the centres of three other provinces, formed in 1994, which are too small in size to mark clearly: Darkhan-Uul, Orkhon and Gobi-Sumber provinces (Дархан-Уул, Орхон, Говь-Сүмбэр) respectively. For more detail see the Central Zone map on page 180.

гол мөрөн	rivers	хил	border
төмөр зам	railway	нийслэл	capital

Language points

Direct speech

Direct speech is the words actually spoken by a speaker, or quotations from written texts, which in English are normally placed within quotation marks. In Mongolian dialogues, quotations usually begin with a dash:

—Та дахиад нэг хэлээд өгөөч?
‘Would you repeat that?’

However, quotation marks (« and ») are used around quotations and proper names:

«Бид маргааш хөдөө явна» гэж дүү надад хэллээ.
‘We are going to the country tomorrow,’ (my) younger brother said to me.

«Баян гол» зочид буудал.
The Bayan Gol Hotel.

Indirect speech

Indirect (reported) speech is a third-person account of what a speaker (or quotation) said; it includes a verb indicating speech, and the speaker’s words are contained in a subordinate clause. In English the subordinate clause usually begins with ‘that’; first- and second-person pronouns change to third-person; and the tenses are back-shifted:

Direct: ‘The second place to which tourists are greatly attracted is the Khangai mountain area.’

Indirect: After that Bat said that the second place to which tourists were greatly attracted was the Khangai mountain area.

In Mongolian the subordinate clause is cited as spoken (quoted), without change of persons or tenses, the verb indicating reported speech coming at the end of the sentence. The subject of the main clause may be separated from the subordinate clause by a comma:

Direct: «Жуулчдын анхаарлыг их татдаг хоёр дахь газар бол Хангайн уулархаг орон юм».

Indirect: Дараа нь Бат, жуулчдын анхаарлыг их татдаг хоёр дахь газар бол Хангайн уулархаг орон юм гэсэн.
Дулмаа надад: «Энэ пальто чамд зохихгүй байна» гэсэн учир авсангүй.

Because Dulmaa said to me, 'This overcoat does not suit you,' I didn't buy it. (Dulmaa told me that the overcoat did not suit me so I didn't buy it.)

Separation of verb from subject

The subject (the speaker) may be separated from the verb indicating speech ('said', 'remarked', etc.) by more than one sentence of the words spoken:

Энэ долоо хоногт цаг агаар ямар байхыг цаг уурч Сарантуяагаас өчигдөр асуухад,
—Хоёрдугаар сарын 19-нд төв, зүүн зүгийн нутгаар цас бударна. Бусад хугацаанд цас орохгүй, зөөлөн салхитай. Хугацааны эцсээр ихэнх нутгаар хүйтний эрч 3-5 хэмээр суларна гэв.

When weather forecaster Sarantuyaa was asked yesterday what the weather would be like this week, (she) said: 'On 19th February there will be snow flurries in central and eastern regions. For the rest (other) of the period it will not snow (and there will be) a gentle wind. Around the end of the period over most regions the intensity of cold will decline by 3-5 degrees.'

The subject (speaker) may also be separated from the words spoken:

Тэгээд хэлмэрчээр дамжуулан хүнээс:
—Та нар явах уу гэж асуув. Тэр хүн:

—Явахгүй гэж байна. Дараагийн хүнээс:

—Явах уу? гэж асуув.

—Явна гэж байна.

So relaying through the interpreter (I) asked the man , ‘Are you going?’ That man says, ‘(We) are not going.’ (I) asked the next man, ‘Are you going?’ ‘(We) are going,’ (he) says.

цаг агаар	weather	цаг уурч	weather forecaster
цас(н)	snow	будрах	to flurry
хугацаа(н)	period	зөөлөн	gentle
салхи(н)	wind	ихэнх	most
эрч	intensity	сулрах	decline
хэлмэрч	interpreter	дамжуулах	to relay

Imperative in -аач

A polite imperative in the second-person singular and plural is formed by adding **-аач** (**-ооч**, **-өөч**, **-ээч**) to the verb stem e.g.

сонсооч (please) listen
дахиад хэлээд өгөөч (please) repeat for me.

Түүнийгээ над үзүүлээч!
 Please show it (that thing of yours) to me!

Та энэ сониноо надад өгөөч! Би уншаад өгье.
 Give me this paper (of yours)! I’ll give (it) when I’ve read (it).

Галт тэрэг явах цаг боллоо, та нар вагондаа суугаач!
 It’s time for the train to leave, please board your carriage!

Verbal noun plus -сан

The suffix **-сан** (**-сон**, **-сөн**, **-сэн**) added to the verbal noun **болох** introduces a wish or want: **Тэрэлж рашаантай юу гэж асуувал болохсон болов уу?** ‘I wonder if perhaps I could ask you whether there is a spring at Terelj.’ This construction is quite common in combination with the conditional converb e.g. **Бид мөнгөгэй бол шинэ гэр авахсан** ‘If we had some money (lit. ‘If we were with money’) we would like to buy a new ger.’

Ordinal numbers

One way of turning cardinal numbers (page 43) into ordinal numbers is to add to the stem without fleeting *n* the suffix **-дэх** (for front vowels) or **-дахь** (for back vowels):

нэгдэх 'first', **хоёрдахь** 'second', **гуравдахь** 'third', **дөрөвдэх** 'fourth', etc.; the stem and suffix are sometimes written separately (**нэг дэх**, **хоёр дахь**, etc.).

Days of the week

Ordinal numbers in **-дэх/-дахь** are used for five days of the week, the numbering beginning from Monday: **нэгдэх өдөр** 'first day':

нэгдэх өдөр	Monday
хоёрдахь өдөр	Tuesday
гуравдахь өдөр	Wednesday
дөрөвдэх өдөр	Thursday
тавдахь өдөр	Friday

Saturday and Sunday however are not 'sixth' and 'seventh' days but **хагас сайн өдөр** 'half good day' and **(бүтэн) сайн өдөр** '(whole) good day', no doubt reflecting the five-and-a-half-day working week which has been in force for many years. These names are used in parallel with the Tibetan-based names (page 74).

Taking one's bearings

Reflecting the duplication of the principal compass points (see page 56), some main subdivisions have multiple forms including the following:

баруун хойно/баруун умар/умар өрнө	north-west
зүүн хойно	north-east
баруун өмнө/баруун урд	south-west
зүүн өмнө/зүүн урд	south-east

As with the principal points, case suffixes indicate location or direction: **зүүн хойшоо** 'to the north-east', **зүүн хойноос** 'from the north-east', **зүүн өмнө рүү** 'to the south-east', **баруун урд зүгт** 'to the south-west', **баруун өмнөд** 'in the south-west', etc.

Use of ablative case

Note that we ask a question ‘from’ someone, using the ablative (-аас, -оос, etc.):

Би танаас нэг юм асуумаар байна.

I would like to ask you something.

Бат надаас, чи энэ номыг уншсан уу гэж асуув.

Bat asked me whether I had read this book.

Noun plurals

For the plural of **уул** ‘mountain’ the text cited gives **уулс**, but some speakers prefer **уулнууд** with fleeting n: (**ууланд** ‘in the mountains’).

The word **Gobi** (**говь**) has a plural too (the Mongols say there are 33 different Gobis), but there is no agreement on which plural form is correct: **Говьнууд**, **Говинууд** or **Говиуд**.

Topic indicators

The dialogue contains several examples of the use of the topic indicator or emphatic particle **бол**: **хоёр дахь нутаг бол ... гурав дахь нутаг бол ... амралтын нэг онцлог бол ...** Its purpose is to emphasise the topic, usually the subject, and in some circumstances to identify it; **бол** may be translated ‘as for’: **одоо бол** ‘nowadays’.

The particles **болбол** and **нь** are used for the same purpose, except that **нь** also suggests belonging to or being part of something: **маргааш** ‘tomorrow’, **маргааш нь** ‘the next day’.

Double negatives

The negative present-future verbal noun **болохгүй** has double negative combinations: **Би явалгүй (бол) болохгүй** ‘I must go.’ **Би ирэлгүй (бол) болохгүй** ‘I must come’ where the literal meaning is ‘Not going is not allowed’, etc. Hence **очилгүй бол болохгүй** ‘not visiting not permitted’, means ‘(You) really must visit!’

Sometimes the present-future verbal noun suffix **-хгүй** may replace **-лгүй**:

Арга хэмжээ авахгүй бол болохгүй.

Measures must be taken. ‘Not taking is not allowed.’

Exercise 1

Translate the following direct speech into Mongolian:

- 1 JULIE: 'Did you understand?'
BAT: 'Yes, I understood.'
- 2 DAVID: 'What book are you reading?'
JULIE: 'I'm reading a guidebook for tourists in Mongolia.'
- 3 DAVID: 'Show me that!'
BAT: 'Wait a bit!'
- 4 JULIE: 'How does one go to Karakorum?'
DELGERMAA: 'One can go by car or by plane.'
- 5 The guidebook says: 'The Gurvan Saikhan mountains are situated in South Gobi province.'

Exercise 2

Translate the following indirect speech into Mongolian:

- 1 Julie asked whether he had understood. Bat replied that he had understood.
- 2 David asked what book she was reading. Julie answered that she was reading a guidebook for tourists in Mongolia.
- 3 David asked Bat to show him that. Bat told him to wait a bit.
- 4 Julie asked how one could go to Karakorum. Delgermaa said one could go by car or by plane.
- 5 The guidebook said that the Gurvan Saikhan mountains were in South Gobi province.

Exercise 3

Pair off the days of the week:

пүрэв хоёрдахь өдөр бүтэн сайн өдөр
 бямба тавдахь өдөр гуравдахь өдөр ням
 дөрөвдэх өдөр мягмар нэгдэх өдөр лхагва
 даваа хагас сайн өдөр баасан

Exercise 4

Translate the following sentences using the polite imperative:

- 1 Please show it (that) to us!
- 2 Give Bat this book of yours!

- 3 Please say that again!
 4 Please board the bus!
 5 Please go by air! (Take a plane!)

Dialogue 2

*Та хэдий хүртэл Хархоринд байх вэ?
 How long will you stay in Kharkhorin?*

Without Bat's guidebook the Browns cannot make up their minds about their trip to Mongolia's ancient capital.

- Бат: Та нар Монголд ирсээр удаж байна уу?
 Девид: Бид Улаанбаатарт ирсээр гурван долоо хоног гаран болж байна. Ажил хэргээр Монголд удаа дараа ирж байна. Энэ удаа зургадугаар сарын хоринд ирсэн.
- Бат: Та ирсээр ямар ажилд голлон анхаарч байна?
 Жюли: Би он гарсаар Монгол улсын тухай нэг ном хийж байна. Манай оюутнуудад хэрэгтэй юм!
- Дэлгэрмаа: Лут их ажил болно доо!
 Жюли: Тийм ээ! Би хэдэн сар номоо бичсээр шөнө орой болтол суув. Би арван нэгэн сарын эцсээр номоо бичиж дуусах хэрэгтэй байна.
- Дэлгэрмаа: Та нар Хархорин руу хэзээ явахаар шийдээд байна?
 Жюли: Шийдээгүй байна. Таныг амралтад яваад иртгэл бид хотод хүлээж байя.
- Бат: Та тэнд аль хэр удаан суух вэ?
 Девид: Сайн мэдэхгүй. Энэ номд юу гэж бичсэн байна вэ?
- Бат: Тодруулбал аль ном?
 Девид: Таны лавлах номд үзье. Бид өнөөдөр шийдэх хэрэгтэй байна.
- Бат: Тэгье, тэгье. Май. Та үнэнээсээ хэлж байна уу?
 Девид: Үнэнээсээ хэлэлгүй яах вэ. Давс хийвэл уустал, ажил хийвэл дуустал гэдэг биз дээ?
- БАТ: *How long have you been staying in Mongolia?*
 DAVID: *We came to Ulan Bator more than three weeks ago. I come to Mongolia on business quite often. This time I arrived on 20th June.*

- BAT: *What work have you been concentrating on since you came?*
- DAVID: *Since the beginning of the year I have been writing a book about Mongolia. My students need it!*
- DELGERMAA: *That's a big job!*
- DAVID: *Yes indeed! For several months I have sat writing my book until late at night. I must finish writing my book by the end of November.*
- DELGERMAA: *Have you decided when you are going to Kharkhorin?*
- JULIE: *We haven't decided yet. We wanted to stay in town until you return from holiday.*
- BAT: *How long will you stay there?*
- DAVID: *I don't know exactly. What does that book say?*
- BAT: *Which book? Explain.*
- DAVID: *Let me have a look at your guidebook. We must decide today.*
- BAT: *Yes, yes. Here you are. Are you serious?*
- DAVID: *Of course I'm serious. Don't they say, never do things by halves? (lit. 'If you add salt let it dissolve; if you do work finish it!')*

ШИНЭ ҮГ Vocabulary

ажил хэргээр	on business	тодруулах	to make clear
амралт	holiday	удаа дараа	repeatedly
анхаарах	to pay attention	удах	to stay, take time
гаран	over, more than	уусах	to dissolve
голлон	mainly	хүрэх	to reach, arrive
лут их	huge, immense	хэрэг	business
май	here you are	шийдэх	to decide
оюутан	student	шөнө орой	late at night

Language points

Continuous converb -саар

The converb adding **-саар** (**-соор**, **-сөөр**, **-сээр**) to the verb stem describes a continuous action going on from the beginning of the main action ('since'):

Та Монголд ирсээр удаж байна уу?

How long have you been staying in Mongolia?

(How long is it that you are staying since you came to Mongolia?)

он гарсаар since the beginning of the year

Би Улаанбаатарт ирсээр гурван жил гаруй боллоо.

It's more than three years since I came to Ulan Bator.

Combined with **байх** the continuous converb means 'keeps on ...':

ирсээр байна

keeps on coming

Би түүнийг хүлээсээр байна.

I have been waiting for him.

Долларын ханш өссөөр байх уу?

Will the dollar exchange rate keep on growing?

Туул голын усны төвшин нэмэгдсээр байна.

Level of Tuul river still rising (newspaper headlines).

Terminal converb -тал

The converb in **-тал** (**-тол**, **-төл**, **-тэл**) describes an action which limits another action, 'until':

Би хэдэн сар номоо бичсээр шөнө орой болтол суув.

'For several months I have sat writing my book until late at night.' ('... sat going on writing my book until it became late ...')

Давс хийвэл уустал, ажил хийвэл дуустал!

If you add salt let it dissolve; if you do work finish it!

(Never do things by halves!)

If the two subjects are different, the first is in the accusative case:

Таныг амралтад яваад иртэл...

Until you return from holiday...

Намайг иртэл хүлээж байгаарай.

Please wait until I come.

Further examples:

Намар болтол тэд энд ажиллана.

They'll work here till autumn (comes).

Сүх далайтал үхэр амар.

The ox is calm until the axe is brandished.

(the lull before the storm)

The word **хүртэл** meaning 'up to', 'as far as', although used independently, is evidently a terminal converb of the verb **хүрэх** 'to reach':

Хэдий хүртэл тэнд байх вэ?

How long (up till when) will you stay there?

Нэрээ хүртэл солив.

(I) even changed (went so far as to change) my name:

Similarly **удтал** 'for a long time' may derive from **удах** 'to stay'.

Ordinal numbers

Another way of turning cardinals into ordinals is to add to the cardinal numbers (stem without fleeting n) the suffix **-дүгээр** (for front vowels) or **-дугаар** (for back vowels): **нэгдүгээр** 'first', **хоёрдугаар** 'second', **гурвдугаар** 'third', **дөрөвдүгээр** 'fourth', etc.; 'sixth' and 'seventh' (**зургадугаар**, **долдугаар**) are slightly irregular, dropping vowels: **арван зургадугаар зуун** 'the 16th century'.

Months of the year

Ordinal numbers in **-дугаар/-дүгээр** are used for months of the year, the numbering beginning from **нэгдүгээр сар** 'first moon/month' or 'January' and ending with **арван хоёрдугаар сар** 'December'.

Alternatively, the months can be counted with cardinal numbers (with fleeting n): **нэг сар**, **хоёр сар**, **гурван сар**, **арван нэгэн сар**.

Days of the month

Cardinal numbers (with fleeting *n*) plus the dative/locative suffixes *-т/-д* are used to indicate on which days of the month an event took place: **ЭНЭ САРЫН НЭГЭНД** ‘on the first of this month’, **ХОЁРТ** (or **ХОЁРОНД**) ‘on the second’, **ГУРВАНД** ‘on the third’, **ХОРИНД** ‘on the 20th’, **ГУЧИНД** ‘on the 30th’.

Other points

Confused about which book Julie is speaking of, Bat says: **Тодруулбал?** ‘Explain?’ He is using the conditional converb (page 82) of the causative verb (page 88) **тодруулах** ‘to clarify’ (from **тод** ‘clear’), ‘if made clear?’

Exercise 5

Translate the following sentences into Mongolian using the continuous converb:

- 1 How long has he been staying in Mongolia?
- 2 The ambassador has been in Ulan Bator more than four years.
- 3 It’s been snowing since the beginning of the year.
- 4 They have been waiting for me.
- 5 Delgermaa has been reading her guidebook.

Exercise 6

Translate the following sentences into Mongolian using the terminal converb:

- 1 Please wait until she comes.
- 2 How long shall we stay here?
- 3 Bat will stay in London until the spring.
- 4 We worked together until Bat went home.
- 5 When I left home it was snowing.

Exercise 7

Translate the following dates into Mongolian:

- 1 My birthday is 24th June.
- 2 Monday is the first day of the week.

- 3 They are coming on Wednesday 3rd October.
- 4 People's Revolution Day is 11th July.
- 5 The 13th December was a Sunday.

Dialogue 3

Одоо яах билээ?

What's to be done now?

Bat uses the guidebook to persuade David that there might be something to see at Karakorum after all.

- Девид: За, лавлах номд «Хархорины дэргэд 1220 (мянга хоёр зуун хорин) онд Алс Дорнод, Дундад Ази, Дорнод Европын худалдааны замын уулзвар дээр худалдаа, гар үйлдвэрийн томоохон хот Хархорум байгуулагджээ» гэж бичжээ.
- Бат: Тэр бүлэгт, Өгөөдэй хааны үед Хархорумыг улсын нийслэл болгож 1235 (мянга хоёр зуун гучин таван) он хүртэл өргөжүүлэн барилгажуулсаар байв гэж үргэлжлүүлэн бичсэн байна.
- Девид: Гэвч лавлах ном, Хархорум хот XVI (арван зургадугаар) зуунд аян дайнд сүйдэж одоо түүний орд харшаас ганцхан суурь чулуу нь л үлджээ гэж тэмдэглэсэн байна. Тэнд юу ч байхгүй!
- Дэлгэрмаа: Харин дараагийн бүлэгт, 1585 (мянга таван зуун наян таван) онд Хархорум хот байсан газрын дэргэд монголын шарын шашны анхны сүм хийдийн нэг Эрдэнэ-Зууг байгуулав гэж бичсэн байна.
- Бат: Зөв. Өндөр цагаан хэрмэн хашаанд гурван сүм бий гэж бичжээ. «Тэдгээр сүмд алт мөнгөөр урлаж хийсэн суварга, цамын баг хувцас, эрдэнийн чулуу шигтгэж алт мөнгөөр хийсэн гоёл чимэглэлийн зүйл олон бий». Ёстой сайхан!
- Жюли: Одоо яах билээ? Хархорин руу явах билетээ одоо бүртгүүлэх үү?
- DAVID: *Ah, the guidebook says, 'Near Kharkhorin a big town of trade and handicrafts named Karakorum*

was founded in 1220 at the junction of trade routes from the Far East, Central Asia and Eastern Europe.'

BAT: *That chapter continues, saying that Karakorum became the country's capital in the times of Ögedei Khan and went on growing and developing until 1235.*

DAVID: *But the guidebook emphasizes that in the 16th century Karakorum town was destroyed in a (military) campaign and now all that remains of its palaces is the foundation stones! There's nothing there!*

DELGERМАА: *On the other hand the next chapter confirms that in 1585 one of the Mongolian 'yellow faith's' first monasteries called Erdene-Zuu was built near the place where Karakorum had been.*

BAT: *Correct. It says that there are three temples inside a white high-walled compound. 'In these temples are many artistically made gold and silver stupas, tsam dance masks and costumes, and gold and silver ornaments set with precious stones.' Wonderful!*

JULIE: *What's to be done now? Shall we get our tickets to Kharkhorin booked now?*

Note: The 'yellow faith' is the Gelugpa or 'yellow hat' form of Tibetan Buddhism which was encouraged in Mongolia after Altan Khan was converted in 1578 by the Tibetan leader Sonam Gyatso, to whom Altan Khan accorded the title Dalai Lama.

ШИНЭ ҮГ Vocabulary

алс	far	өргөжүүлэх	to broaden
алт(ан)	gold	өндөр	high
анх(ны)	first	суварга	stupa, shrine
байгуулах	to build	суурь (суурин)	foundations
барилгажуулах	to develop	сүйдэх	to be destroyed
билет	ticket	томоохон	big, important
бүлэг	chapter	тэдгээр	those
бүртгүүлэх	to get booked	тэмдэглэх	to emphasize
ганцхан	only	урлах	to make artistically
гоёл чимэглэл	ornament	үе	time, period

дайн	war	үлдэх	to stay, remain
аян дайн	campaign	хашаа(н)	enclosure
ёстой	truly, really	хувцас(н)	clothing
зөв	correct	хэрэм(н)	wall, fortress
зүйл	object	шашин	religion
зуун	century	шигтгэх	to inlay
орд харш	palaces	эрдэнэ	jewel

Language points

Modal converb -ан

The modal converb is formed by adding **-н** to the verb stem. Stems ending in a consonant or soft sign need a linking vowel: **-ан**, **-он**, **-өн**, **-эн**. It is widely used in various combinations to express an action occurring simultaneously or merging with that of the main verb. Previous examples we have seen include **худалдан авах** 'to buy', 'selling take', where **худалдан** is the modal converb of the verb **худалдах** 'to sell'; and **хүлээн авах** 'to receive', 'receiving take', **хүлээн** coming from **хүлээх** 'to receive', 'wait for'. The combinations create new words in English: another example is **хамтран ажиллах** 'to cooperate', 'acting jointly work' where **хамтрах** means 'to act jointly'. In the case of **зохион байгуулах** 'to organize', 'composing build' the modal converb **зохион** is derived from **зохиох** meaning 'to compose'.

A particularly polite verb **морилох** 'to deign to' is combined in its modal converb form **морилон** with other verbs to make requests e.g. **Морилон орно уу?** 'Would you be so kind as to enter?' Don't confuse this converb in vowel plus **-н** with the present-future tense in **-н** plus vowel: **Тавтай морилно уу?** is translated as 'Welcome!' (**тавтай** means 'pleasant', 'undisturbed').

Causative verbs

We saw (page 88) that the derivational suffix **-уул-** attached to the verb stem created a class of causative verbs, indicating that an action was caused (or permitted). In this dialogue there is a more complex example: **өргөжүүлэн барилгажуулсаар байв** meaning 'went on growing and developing'. Here **өргөжүүлэн** is the modal converb of the causative **өргөжүүлэх** 'to grow', 'broaden' from **өргөжих** 'to expand'; and **барилгажуулсаар** is the continuous

converb of the causative **барилгажуулах** 'to build up, develop', from **барилгажих** 'to become developed'.

Passive verbs -гд-

The derivational suffix **-гд-** is the usual one for forming the passive, e.g. in Dialogue 3 **байгуулагджээ** 'was founded', from **байгуулагдах** 'to be founded', from **байгуулах** 'to build', also 'to found, organize'. Other examples: **нээх** 'to open,' **нээгдэх** 'to be opened', **таалах** 'to like', **таалагдах** 'to please'.

The agent of a passive verb is in the dative/locative case: **нохойд нээгдсэн хаалга** 'the door opened by the dog'.

A few passives are formed with the derivational suffixes **-д-** e.g. **олдох** from **олох** 'to find' and **-т-** e.g. **автах** from **авах** 'to take'.

More about cardinal numbers

The cardinal numbers (page 43) for 40 to 90 are as follows:

40	дөч(ин)	50	тавь(тавин)
60	жар(ан)	70	дал(ан)
80	ная(н)	90	ер(эн)

Used together with **зуу(н)** 'hundred' and **мянга(н)** 'thousand' we can indicate the year (the fleeting n is present when counting objects, but not for **мянга** when counting years):

1220: **мянга хоёр зуун хорин он**
in 1997: **мянга есөн зуун ерэн долоон онд**

Cardinal numbers (without fleeting n) plus the dative/locative suffix **-т/-д** indicate in which year, or at which number room or house e.g. **арвад** 'at No. 10', **хорин нэгд** in '(19)21', **гучид** 'in '30', etc.

Exercise 8

Translate the following sentences using modal converbs:

- 1 The khan received him on Sunday.
- 2 The Great Khural organized a new government.
- 3 The teacher will buy a new book on Monday.
- 4 Mongolia and Great Britain are cooperating.
- 5 Julie was looking in fright at Begtse.

Exercise 9

Create the passive forms of the following active verbs:

- 1 мэдэх 'to know' 2 алах 'to kill', 3 идэх 'to eat'
4 сонсох 'to hear' 5 нээх 'to open'

Exercise 10

Translate the following sentences with numbers into Mongolian:

- 1 Temüjin became Genghis Khan in 1206.
- 2 My birthday is 22nd April 1989.
- 3 You should travel by train No. 103.
- 4 Our university has ten thousand students.
- 5 Bat has four thousand six hundred and fifty sheep.

Dialogue for comprehension 5 

- Девид: Чи ямар ном уншиж байна вэ?
Жюли: Би Монголд байгаа жуулчны нэг лавлах ном уншиж байна.
- Девид: Түүнийг над үзүүлээч!
Жюли: Жаахан хүлээж бай! Лавлах номд, «Говь нутгийн жуулчид их очдог газрын нэг нь Гурван сайхан уулсын Ёлын ам дархан цаазат газар байна» гэж бичсэн байна.
- Девид: Жуулчдыг их татдаг өөр газар хаа байна вэ?
Бат: Жуулчдыг их татдаг өөр нутаг бол Хангайн уулархаг орон юм. Дэлхий дахинд нэрд гарсан Хархорумын балгас, Эрдэнэ-Зуу хийд тэнд оршдог.
- Жюли: Жуулчид их цугладаг гурав дахь нутаг бол Хэнтийн уулархаг оронд хамаарах Тэрэлж билээ гэж бас бичсэн байна. Тэрэлж эндээс холгүй юу?
Бат: Холгүй. Улаанбаатарын зүүн хойд зүгт машинаар нэг цаг явах газар оршдог юм.
- Девид: Хархорум руу яаж явах вэ?
Бат: Автобус, нисэх онгоцоор Хархорин хот руу явж болно. Та нар Хархорин руу хэзээ явахаар шийдэв?
- Дэлгэрмаа: Та хэдий хүртэл тэнд байх вэ?

- Жюли: Та бидэнд олон асуулт тавилаа шүү дээ! Одоохондоо шийдээгүй л байна. Таны лавлах номыг үзье.
- Девид: Харин лавлах номд, «Хархорум хот XVI зуунд дайнд сүйдэж одоо түүний орд харшаас ганцхан суурь чулуу нь үлджээ» гэж бичсэн байна. Тэнд үзэх юм юу ч байхгүй юу?
- Дэлгэрмаа: Харин энэ номын дараагийн бүлэгт, 1585 онд Хархорум хот байсан газрын дэргэд монголын шарын шашны анхны сүм хийд Эрдэнэ-Зууг байгуулав гэж бичжээ.
- Девид: За, Хархорин руу нисэх билетээ бүртгүүлэх үү?

машин	car, vehicle	одоохондоо	for the moment
-------	--------------	------------	----------------


Crossword

босоо	down	заг	saxaul shrub
хөндлөн	across	нуруу(н)	mountain range
даваа(н)	mountain pass	нуур	lake

clues:

ХӨНДЛӨНГӨӨР:

- 3 Mongolian for 'mountain pass'
- 6 Дархан-Уул аймгийн төв
- 8 River on which Ulan Bator stands
- 10 Mongolian for 'river'
- 12 Арвайхээр төвтэй аймаг
- 15 Мөрөн төвтэй аймаг
- 16 Abbreviation for Mongolia's capital city
- 17 Монголын хамгийн том мөрөн; Сүхбаатар төвтэй аймаг
- 18 Mongolian for 'gorge' or 'mouth'
- 21 Баянхонгор төвтэй аймаг
- 23 Mongolian for 'mountain range'
- 24 Чойбалсан төвтэй аймаг
- 25 Mongolian for 'town'
- 26 Архангай аймгийн төв



- 27 Big river in eastern Mongolia
 30 Хөвсгөл аймгийн төв
 31 Mongolian for 'mountain'
 32 Улиастай төвтэй аймаг
 34 Ховд төвтэй аймаг
 35 Мандалговь төвтэй аймаг
 38 Булган төвтэй аймаг
 39 Salt lake in western Mongolia
 44 Дорноговь аймгийн төв
 45 Mongolian for 'west'
 46 Mongolian for 'east'
 47 Хятадтай хиллэдэг том нуур
 48 Mongolian for 'cave'

босоогоор:

- 1 Өлгий төвтэй аймаг
- 2 Mongolian for 'snow'
- 4 Говь-Алтай аймгийн төв
- 5 A desert shrub
- 7 Монгол улсын нийслэл
- 9 Монголын баруун хойд аймаг, том нуур хоёр
- 11 Том хот, Орхон аймгийн төв
- 12 Хэнтий аймгийн төв
- 13 Цэцэрлэг төвтэй аймаг
- 14 Чойр төвтэй аймаг
- 19 Алтай төвтэй аймаг
- 20 Mongolian for 'south'
- 22 Зүүн хойно Монголын нэг гол
- 24 Өмнөговь аймгийн төв
- 28 Mongolian for 'lake'
- 29 Увс аймгийн төв
- 33 Дорнод аймгийн төв
- 36 Монголын хамгийн урт гол, Эрдэнэт төвтэй аймаг
- 37 Mongolian for 'state' or 'nation'
- 40 Mongolian for 'mineral spring'
- 41 Монголын зүүн хойд аймаг
- 42 Mongolian for 'province'
- 43 Mongolian for 'homeland'

6 Өргөстэй боловч өөрийн нутаг

There's no place like home

In this lesson you will learn:

- About buying air tickets
- About booking into a hotel
- Use of the concessive converb (although)
- Use of the optative converb (if only)

Dialogue 1

МИАТ-ийн билетийн касс дээр
At the MIAT ticket office

David and Julie go to the Mongolian airlines office in Ulan Bator to buy their tickets for Kharkhorin.

- Девид: «МИАТ» гэж энэ юу гэсэн утгатай үг вэ?
Жюли: МИАТ бол «Монголын иргэний агаарын тээврийн» компанийн нэр.
- Девид: Одоо чиний оочир боллоо!
Үйлчлэгч: Танд яаж тус болохсон бол?
Жюли: Бид Хархорин хүртэл хоёр хүний суудал захиалмаар байна.
- Үйлчлэгч: Та хэдийний онгоцоор явах санаатай байна?
Жюли: Нөгөөдөрийн онгоцоор явах уу?
Үйлчлэгч: Явна аа! Онгоц Буянт-Ухаагаас өглөөний найман цаг арван таван минутад ниснэ.
- Жюли: Нэг билет ямар үнэтэй вэ?
Үйлчлэгч: Нэг талын билет арван мянган төгрөг гэвч гадаадынхан «ногооноор» төлөх хэрэгтэй.
- Жюли: За, хэдэн доллар вэ?

- Үйлчлэгч: Хоёр талын билет хоёр зуун доллар.
 Жюли: Өө за. Хоёр билет авъя. Май дөрвөн зуун доллар энэ байна.
 Девид: Онгоцонд хэдэн кило ачаа авч явж болдог юм бэ?
 Үйлчлэгч: Нэг хүн 20 кило ачаа авч явж болдог.
 Жюли: Хэдийд онгоцны буудалд очсон байх учиртай вэ?
 Үйлчлэгч: Онгоц нисэхээс нэг цагийн өмнө буудалд очсон байх хэрэгтэй.

Note: Buyant-Ukhaa is the location of Ulan Bator airport, 20 minutes' drive south-west of the town centre.

- DAVID: *What does this word 'MIAT' mean?*
 JULIE: *MIAT is the name of the Mongolian civil air transport company.*
 DAVID: *Now it's your turn.*
 ASSISTANT: *How may I help you?*
 JULIE: *We would like to book two seats to Kharkhorin.*
 ASSISTANT: *Which day are you thinking of flying?*
 JULIE: *Can we take (go by) the plane the day after tomorrow?*
 ASSISTANT: *Certainly. The plane leaves Buyant-Ukhaa at 8.30 am.*
 JULIE: *How much does a ticket cost?*
 ASSISTANT: *A single ticket is 10,000 tögrög, but foreigners have to pay in greenbacks.*
 JULIE: *Well, how many dollars?*
 ASSISTANT: *A return ticket is 200 dollars.*
 JULIE: *OK, let me have two tickets. Here are 400 dollars.*
 DAVID: *How many kilos of baggage can you take on the plane?*
 ASSISTANT: *Twenty kilos per person.*
 JULIE: *What time should we be at the airport?*
 ASSISTANT: *You must be at the airport an hour before departure time.*

ШИНЭ ҮГ

Vocabulary

агаар	air	санаа	intention
ачаа(н) (тээш)	baggage	суудал	seat
доллар	dollar	төгрөг	tugrik (Mongol currency, see note below)
иргэний	civil(ian)		

касс(ан)	cash desk	төлөх	to pay
кило	kilo(gram)	тус	assistance
компани	company	утга	meaning
нисэх	to fly	учиртай	should (do)
нөгөөдөр	the day after tomorrow	үг(н)	word
оочир	queue; turn	хэдийний	of which date?
өглөө	morning	хэрэгтэй	necessary

Note: Although *tögrög* is the correct transliteration from the Mongolian Cyrillic, the spelling *tugrik*, derived earlier via Russian, is still found in English publications which avoid the use of diacritics. Both forms are used interchangeably in this book.

Language points

Multiple imperfective converbs

The MIAT assistant asks Julie **Танд яаж тус болохсон бол?** ‘How may I help you?’ In the first part of this question **яаж** is the imperfective converb of **ях** ‘to do what?’ and **тус** means ‘help’ or ‘assistance’. Alternatively, **Танд яаж тусалж болохсон бол?** uses two imperfective converbs (**туслах** means ‘to assist’). Towards the end of the dialogue there is another example of multiple use of imperfective converbs: (**ачаа**) **авч явж болдог**. In this case **авч** from **авах** ‘to take’ and **явж** from **явах** ‘to go’ are combined with **болдог** from **болох** ‘to become’, ‘be permitted’ to mean ‘taking/going is regularly permitted’.

Verbal noun plus -сан

In the MIAT assistant’s question the addition of the suffix **-сон** (page 99) to the verbal noun **болох** (**болохсон**) modifies the meaning: ‘would like to have done’.

Final particle бол

The **бол** at the end of the assistant’s question plays a different role from the conditional **бол** (page 83). Ending a sentence, **бол** is a final particle expressing uncertainty – ‘perhaps?’

Therefore **Танд яаж тус болохсон бол?** breaks down as ‘To you doing what assistance (I) would like to render perhaps?’ expressing a polite but tentative interest.

Colours

The MIAT assistant asks for **ногоон** ‘greens’, a slang term meaning dollars. For the Mongols colours (**өнгө**) have important traditional associations. We have already noted **шарын шашин** ‘the yellow faith’ (Lamaism), and a Mongolian lama is still sometimes called **шар малгайтан** ‘person with a yellow hat’ (**малгай** is ‘hat’), to distinguish him perhaps from an **улаан малгайтан** ‘person with a red hat’ or unreformed Buddhist. During the communist years there were **ногоон малгайтнууд** too – the security police. Black **хар** means ‘lay’ or ‘secular’ (as opposed to **шар**) or ‘hard’, ‘heavy’: **хар ажил** ‘hard work’. On the other hand **харын шашин** the ‘black faith’ is shamanism.

The red of the communist revolution is reflected in **Улаанбаатар хот** ‘town of the red hero’ (or possibly ‘heroes’), the Mongolian capital **Нийслэл хүрээ** ‘capital monastery’ renamed in 1924 after the **улаантан** or **улааныхан** ‘the Reds’ had beaten ‘the Whites’ or **цагаантан**. The Altai mountains are the ‘golden’ mountains from **алт(н)**, and the first settlement on Mongolian soil to be captured by the revolutionaries in 1921 is now called Altanbulag (**Алтанбулаг** ‘golden spring’). The word for ‘silver’, **мөнгө** gave its name to ‘money’ and to what used to be Mongolia’s smallest coins: 100 **мөнгө** = 1 **төгрөг**. The word **төгрөг** means ‘round’.

Returning to traditional themes, **улаан идээ** ‘red food’ is meat, in contrast to **цагаан идээ**, which is what the Mongols call butter, cheese, cream and other milk products including **айраг**, koumiss or fermented mare’s milk; these are mostly consumed in the summer months. There are secondary meanings for **цагаан** too: ‘pure’ e.g. **цагаан сэтгэл** or **цагаан санаа** ‘good nature’, also ‘flat’, e.g. **цагаан зам** ‘a smooth road’ or ‘bare’, ‘open’, e.g. **цагаан газар** ‘open country’.

To describe the colour of something, you may say that it is ‘with ... colour’ using the comitative case: **Миний малгай хар өнгөтэй** ‘My hat is black.’

More about numerals

To express the idea of 'so many times' the cardinal numbers may be used (without fleeting *n*) or the suffix **-таа** added to the *n*-stem form e.g.

гурвантаа	three times
дөрвөнтөө	four times
арвантаа	ten times, etc.
гурвантаа буудсан	fired three times

Addition of the suffix **-т** means 'with the number *x*':

аравт	with the number 10
аравтын дэвсгэр	10-tögrög banknote

Note however **нэг номерын троллейбус** 'a No. 1 trolleybus'.

Other points

The multiple compound **гадаадынханд** breaks down as follows: **гадаа** 'outside', **гадаад** 'external', 'foreign', **гадаадын** 'of the foreign', **гадаадынхан** 'people of the foreign (parts)', **гадаадынханд** 'to people of foreign parts' (dative/locative case).

The word **очир** is from the Russian **очередь** meaning both 'turn' and 'queue'; there is also a Mongol word for queue: **дараалал** (verbs: **дараалах**, **дараалан зогсох**).

НЭМЭЛТ ҮГ

Additional vocabulary

зохицуулалт	check, regulation	улирал	season
зун	summer	хоёр талын үнэ	return fare
мөрдөх	to follow	хөдлөх	to move
нислэг	flight	хуваарь/хувиар	timetable
олон улсын	international	хэлтэс	department
тасалбар	ticket	чиглэл	direction

**Орон нутагт ямар хуваариар
нисэх вэ?**

Чиглэл (Аялал, Онгоц)	Өдрүүд	Нисэх
УБ-Өндөрхаан-Дадал-Биндэр (337, Ю-12) Биндэр-Дадал-Өндөрхаан-УБ (338, Ю-12)	.2...6. .2...6.	09 40
УБ-Баруун-Урт (331, АН-24) Баруун-Урт-УБ (332, АН-24)	1.3.5.. 1.3.5..	08 40 11 25
УБ-Чойбалсан (333, АН-24) Чойбалсан-УБ (334, АН-24)	1.3.5.. 1.3.5..	08 20 10 50
УБ-Мандалговь (451, Ю-12) Мандалговь-УБ (452, Ю-12)	.2..5.. .2..5..	09 50 11 35
УБ-Даланзадгад (447, АН-24) Даланзадгад-УБ (448, АН-24)	.2..5.. .2..5..	09 20 11 35
УБ-Баянхонгор (553, АН-24) Баянхонгор-УБ (554, АН-24)	1..4.6. 1..4.6.	10 00 12 20
УБ-Өвөрхангай-Хархорин (555, АН-24) Хархорин-Өвөрхангай-УБ (556, АН-24)	1..4...	08 30
УБ-Цэцэрлэг (453, Ю-12) Цэцэрлэг-УБ (454, Ю-12)	..3.6. ..3.6.	09 20 11 35
УБ-Булган-Тэшиг (443, Ю-12) Тэшиг-Булган-УБ (444, Ю-12)	1..4... 1..4...	09 20
УБ-Мөрөн (557, АН-24) Мөрөн-УБ (558, АН-24)	1.3.5.. 1.3.5..	09 05 11 20
УБ-Алтай (551, АН-24) Алтай-УБ (552, АН-24)	.2.4.6. .2.4.6.	09 05 11 50
УБ-Улиастай (567, АН-24) Улиастай-УБ (568, АН-24)	.2.4.6. .2.4.6.	08 40 11 25
УБ-Тосонцэнгэл (563, АН-24) Тосонцэнгэл-УБ (564, АН-24)	1.3.5.. 1.3.5..	09 40 12 20
УБ-Ховд (571, АН-24) Ховд-УБ (572, АН-24)	.2.4.6. .2.4.6.	08 20 12 45
УБ-Ховд-Булган (571, АН-24) Булган-Ховд-УБ (572, АН-24)5..5..	07 50
УБ-Өлгий (561, АН-24) Өлгий-УБ (562, АН-24)	.2.4.6. .2.4.6.	08 00 12 45
УБ-Улаангом (573, АН-24) Улаангом-УБ (574, АН-24)	1.3.5.. 1.3.5..	08 00 12 35
УБ-Эрдэнэт (457, Ю-12) Эрдэнэт-УБ (458, Ю-12)6.6.	08 50 16 00
УБ-Өмнөговь Тур. бааз* (447, АН-24) Өмнөговь Тур. бааз-УБ (448, АН-24)	1234567 1234567	07 40 09 50

* Тур. бааз 'tourist base' (Russian)

ОЛОН УЛСЫН НИСЛЭГИЙН ӨВЛИЙН ХУВААРЬ

Чиглэл	Хөдлөх	Буух	№.
УБ/Бээж*	Дав/Бям 10.30	12.30	ОМ223
УБ/Бээж	Лхаг 15.00	17.00	ОМ223
УБ/Бээж	Мя/Ба 14.35	15.25	СА902
УБ/Бээж	Мяг 13.35	14.35	СА902
Бээж/УБ	Дав/Бям 14.30	16.30	ОМ224
Бээж/УБ	Лхаг 18.00	20.00	ОМ224
Бээж/УБ	Мя/Ба 10.35	12.45	ОМ224
Бээж/УБ	Мя/Ба 10.35	13.35	СА901
Бээж/УБ	Пүр 10.35	12.45	СА901
УБ/Сөүл	Ба 09.00	13.20	ОМ8027
УБ/Сөүл	Мя 14.30	17.40	КЕ6605
Сөүл/УБ	Ба 15.00	17.30	ОМ8028
Сөүл/УБ	Мя 10.00	13.30	КЕ6605
УБ/Москва	Пү/Ня 08.05	11.35	ОМ135
УБ/Москва	Мя 12.00	15.00	SU563
Москва/УБ	Мя/Ня 08.10	08.40	ОМ136
УБ/Иркутск	Лх/Бя 09.00	10.30	-
Иркутск/УБ	Лх/Бя 12.30	14.00	-
УБ/Хөх хот	Да/Пү 08.00	10.40	-
Хөх хот/УБ	Да/Ням 12.20	15.00	-
УБ/Берлин	Ням 08.05	14.15	ОМ135
Берлин/УБ	Ням 15.50	08.40	ОМ136

*Бээж is short for Бээжин – Beijing

ОМ=МИАТ СА=Айр Чайна SU=Аэрофлот КЕ=Корейн Айр

Тасалбарын үнэ: УБ - Бээжин 100.000Төг, хоёр талын үнэ
190.000Төг

УБ - Москва 189.000Төг, хоёр талын үнэ
379.000Төг

УБ - Сөүл зөвхөн хоёр талын үнэ
385.000Төг

УБ - Иркутск 34.650Төг, хоёр талын үнэ
69.300Төг

УБ - Хөх хот 47.950Төг, хоёр талын үнэ
95.900Төг

УБ - Берлин 292.500Төг, хоёр талын үнэ
540.000Төг

Энэ үнэ нь зөвхөн Монголын иргэдэд л хамаарна.

Exercise 1

Translate into Mongolian:

- 1 I don't know how to ask him.
- 2 If we had a car we would like to go to Kharkhorin.
